

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2023 оны 04 сарын 05**

Тендер шалгаруулалтын нэр: **Усны гутал, хувцас**
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202312403**

“Монголросцветмет” ТӨҮГ нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг **“Усны гутал, хувцас”** нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш 30 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заах ба **төсөвт өртгийн 0.5%-иас багагүй** үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 09:00 цагаас** өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг **2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 09:10 цагт** зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхтэй.**
Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: **Үгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

www.tender.gov.mn

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ